

Банкуудын зээлийн тайлан

2017 оны 7 дугаар сар

Хураангуй мэдээлэл:


- Банкуудын *нийт зээлийн үлдэгдэл 2017 оны 7 дугаар сарын байдлаар 12.9 их наяд төгрөгт хүрснээс 79.3 хувь нь төгрөгийн зээл байна.*
- Тайлант сард шинээр *951.9 тэрбум төгрөгийн зээл олгогдсоны 85.2 хувь нь төгрөгийн зээл байна. Харин 904.8 тэрбум төгрөгийн зээл төлөгдөв.*
- Нийт зээлийн үлдэгдлийн *6.9 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 8.8 хувийг чанаргүй зээл бүрдүүлж байна. Усан хангамж бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны салбарын чанаргүй зээл 47.3 хувь, уул уурхай олборлолт 25.5 хувь, боловсруулах үйлдвэр 17.4 хувь, худалдааны салбар 10.3 хувь, барилгын салбар 8.9 хувьтай байна.*
- Нийт хэвийн зээлийн үлдэгдлийн *60.9 хувийг 1-5 жилийн хугацаатай зээл, 21.6 хувийг 5 ба түүнээс дээш жилийн хугацаатай зээл, 17.4 хувийг 1 жил хүртэлх хугацаатай зээл бүрдүүлж байна. Харин тайлант сард олгосон зээлийн 47.9 хувь нь 1 жил хүртэл хугацаатай, 40.5 хувь нь 1-5 жил хүртэл хугацаатай, 11.7 хувь нь 5 ба түүнээс дээш жилийн хугацаатай олгогджээ.*
- Нийт зээлийн үлдэгдлийн *51.8 хувийг хувийн хэвшилд, 47.1 хувийг иргэдэд олгосон зээл эзэлж байна. Тухайн сард олгосон зээл өмнөх оны мөн үеэс 27.8 хувиар өссөнөөс хувийн хэвшилд олгосон зээл 7.7 хувиар, иргэдэд олгосон зээл 47.1 хувиар тус тус өсчээ.*
- Банкууд 2017 оны 7 дугаар сарын байдлаар 43.9 мянган ЖДҮ эрхлэгчдийн олгосон 2.1 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.
- Тухайн сард ЖДҮ эрхлэх зориулалтаар *ААН-үүдэд 91.2 тэрбум төгрөгийн зээлийг жилийн 17.4 хувийн дундаж хүүтэй, 1.7 жилийн дундаж хугацаатай, иргэдэд 87.5 тэрбум төгрөгийн зээлийг жилийн 22.5 хувийн дундаж хүүтэй, 1.1 жилийн дундаж хугацаатай олгожээ.*

Нийт зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеээс 7.6 хувиар өсч 12 их наяд 941.1 тэрбум төгрөгт хүрчээ. Үүнээс *татан буугдсан*¹ банкуудын зээлийн үлдэгдлийг хасч тооцвол 12 их наяд 742.6 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеээс 7.9 хувиар өссөн үзүүлэлт юм. Харин банкуудаас *Монголын Ипотекийн Корпорацид шилжүүлсэн*² багцыг оруулж тооцвол нийт зээлийн үлдэгдэл 15 их наяд 378.7 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеээс 8.1 хувийн өсөлттэй байна.


Нийт зээлийн үлдэгдлийн 79.3 хувь нь төгрөгийн, 20.7 хувь нь валютаар олгогдсон зээл байна. Боловсрол, санхүү даатгал, цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж, мэргэжлийн, шинжлэх ухааны салбарт валютын зээл давамгайлж байна.

Тайлант сард банкууд нийт 951.9 тэрбум төгрөгийн зээл шинээр олгосон байна. Олгосон зээл өмнөх сараас 437.1 тэрбум төгрөгөөр буюу 31.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна. 7 дугаар сарын байдлаар нийт 904.8 тэрбум төгрөгийн зээл төлөгдсөн бөгөөд өмнөх сартай харьцуулахад 20.7 хувиар буурсан байна.

Зураг 1. Зээлийн үлдэгдэл



Зураг 2. Зээлийн үлдэгдэл /төгрөг, валютаар/



Зураг 3. Олгосон, төлөгдсөн зээл



¹ Зоос, Хадгаламж банк.


² МИК-д шилжүүлсэн 2.43 их наяд төгрөгийн зээлийн дүн нь банкны салбарын үзүүлэлтээс хасагдаж, бусад санхүүгийн байгууллагын үзүүлэлтэд тусгагддаг.

Олгосон зээлийг валютаар нь авч үзвэл мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа, байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа, боловсрол, төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, усан хангамж бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа, хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны зээлүүд 100 хувь төгрөгөөр олгогдсон байгаа бол мэдээлэл холбооны салбарт дийлэнх нь гадаад валютаар олгогдсон байна.


Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь 8.8 байна. Харин салбаруудаар нь авч үзвэл усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны салбарын чанаргүй зээл 47.3 хувь, уул уурхай олборлолт 25.5 хувь, боловсруулах үйлдвэрийнх 17.4 худалдааны салбарынх 10.3 хувь, барилгын салбарынх 8.9 хувьтай байна.

Шинээр олгосон зээлийг салбаруудаар ангилан авч үзвэл 38.7 хувийг хэрэглээ, цалин тэтгэврийн зээлд, 22.1 хувийг худалдааны салбарт, 9.7 хувийг боловсруулах үйлдвэрт, 6.4 хувийг уул уурхай олборлолт, 4.5 хувийг үл хөдлөх хөрөнгө, 3.7 хувийг барилгын салбарт тус тус олгожээ.


Зураг 4. Олгосон зээл /төгрөг, валютаар/



Зураг 5. Нийт зээлийн үлдэгдэлд эзлэх чанаргүй зээлийн хувь /салбараар/




Зураг 6. Олгосон зээл /салбараар/




Тайлант сард нийт олгосон зээлийн 47.9 хувийг 1 жил хүртэл хугацаатай зээл, 40.5 хувийг 1-5 жил хүртэл хугацааны зээл, 11.7 хувийг 5 ба түүнээс дээш жилийн хугацаатай олгогджээ.

Хугацаа хэтэрсэн зээлийг гол салбаруудаар авч үзвэл уул уурхайн салбар 26.0 хувь, барилгын салбар 11.2 хувь, худалдааны салбарт 8.5 хувь, боловсруулах үйлдвэрт 7.2 хувь, хэрэглээний зээл 1.9 хувьтай байна.

Зураг 7 Олгосон зээл /хугацааны ангиллаар/



Зураг 8. Чанаргүй зээл, хугацаа хэтэрсэн зээл /түхэйн салбартаа эзлэх хувиар/



Банкууд чанаргүй зээлээс үүдэж гарах алдагдлаас хэр хамгаалагдсан байгаа эсэхийг тодорхойлдог нөөцийн хүрэлцээний харьцаа (provision coverage ratio)-г салбар бүрээр авч үзвэл захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа³, цахилгаан хий, уур, агааржуулалтын хангамж, боловсрол, уул уурхай, олборлолтын салбарын зээл хүрэлцээтэй түвшинд байгаа бол усан хангамж, хөдөө аж ахуй, үл хөдлөх хөрөнгийн үйл

Зураг 9. Эрсдэлийн сан болон чанаргүй зээлийн харьцаа



³ Захиргаа болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарын эрсдэлийн сан ба чанаргүй зээлийн харьцаа 333.8 хувьтай байна. Зураг 10-т харуулаагүй болно.

ажиллагаа, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, хүний эрүүл мэндийн салбар дахь уг харьцаа бага байна.

Хувийн хэвшлийн зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 0.4 хувиар өсч 6 их наяд 700.7 тэрбум төгрөгт, иргэдийн зээл 16.7 хувиар өсч 6 их наяд 94.7 тэрбум төгрөгт тус тус хүрэв.


Хувийн хэвшлийн зээлийн үлдэгдлийн 20.7 хувь нь худалдааны салбарт, 20.6 хувь нь боловсруулах үйлдвэрт, 16.4 хувь нь барилгын салбарт, 12.3 хувийг уул уурхай олборлолтын салбарт ногдож байна.

МИК-д шилжүүлсэн зээлийн багцыг оруулж тооцвол иргэдийн зээл өмнөх оны мөн үеэс 14.7 хувиар өсчээ.


Иргэдийн зээлийн үлдэгдлийн 28.1 хувь буюу 1 их наяд 712.4 тэрбум төгрөг ипотекийн, 30.6 хувь буюу 1 их наяд 862.8 тэрбум төгрөг цалингийн, 12.5 хувь буюу 763.3 тэрбум төгрөг бусад зээлд, 12.0 хувь буюу 730.1 тэрбум төгрөг жижиг дунд үйлдвэрийн, 10.8 хувь буюу 655.3 тэрбум төгрөг тэтгэврийн, 6.1 хувь буюу 370.7 тэрбум төгрөг хэрэглээний зээл байна.

Нийт иргэдийн зээлийн үлдэгдлийн 3.7 хувийг чанаргүй зээл эзэлж байна.


Зураг 10. Хувийн байгууллагын зээлийн үлдэгдэл



Зураг 11. Иргэд, хувийн хэвшилд олгосон зээлийн жилийн өсөлт



Зураг 12. Иргэдийн зээл /зориулалтаар/




- МИК-д шилжүүлсэн зээлийн багц
- Бусад
- Тэтгэврийн зээл
- Цалингийн зээл
- Хэрэглээний зээл
- Жижиг, дунд үйлдвэрийн зээл
- Ипотекийн зээл

Зураг 13. Иргэдийн чанаргүй зээлийн хувь /зориулалтаар/

Харин иргэдийн ипотекийн зээлийн 3.4 хувь, цалингийн зээлийн 1.8 хувь, бусад зээлийн 3.0 хувь, хэрэглээний зээлийн 2.6 хувь, тэтгэврийн зээлийн 0.4 хувь нь чанаргүй зээл байна.

Тайлант сард иргэдэд олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү жилийн 18.1 хувь, цалингийн зээл 20.1 хувь, хэрэглээний зээл 20.4 хувь, бусад зээл 14.4 хувь, тэтгэврийн зээл 17.8 хувьтай байна.



Харин хугацаагаар нь авч үзвэл ипотекийн зээлийн дундаж хугацаа 17.6 жил, цалингийн зээл 3.4 жил, бусад зээл 1 жил, хэрэглээний зээл 2.1 жил, тэтгэврийн зээлийн хугацаа 7.2 сарын хугацаатай байна.


Тайлант сарын эцсийн байдлаар ЖДҮ эрхлэх зориулалтаар аж ахуйн нэгж болон иргэдэд олгосон нийт зээлийн үлдэгдэл 2 их наяд 136.3 тэрбум төгрөг байна. ЖДҮ эрхлэх зориулалтаар ААН-д олгосон зээлийн үлдэгдлээс хамгийн өндөр 32.6 хувь буюу 458.9 тэрбум төгрөгийн зээлийг боловсруулах үйлдвэрт, 24.8 хувь буюу 348.2 тэрбум төгрөгийг худалдааны салбарт олгожээ. Харин ЖДҮ эрхлэх зориулалтаар иргэдэд олгосон зээлийн 49.7 буюу 362.5 тэрбум төгрөгийн зээлийг худалдааны салбарт олгосон байна.

ЖДҮ-ийн зориулалтаар олгосон нийт зээлийн үлдэгдлийн 14.3 хувь нь чанаргүй зээл болжээ.

Зураг 14. Иргэдийн зээлийн жигнэсэн дундаж хугацаа


Зориулалт	Зээлийн дундаж хүү /хувь/	Зээлийн дундаж хугацаа /сар/
Ипотекийн зээл	11.5	210.8
Хэрэглээний зээл	20.4	25.2
Цалингийн зээл	20.1	40.2
Тэтгэврийн зээл	17.8	7.2
Бусад зээл	14.4	12.4

Зураг 15. ЖДҮ-ийн зээл /олгосон салбараар/



Салбараар нь авч үзвэл ЖДҮ-ийн зориулалтаар аж ахуйн нэгжид олгосон зээлийн хувьд үйлчилгээний салбарын чанаргүй зээл 27.2 хувь, иргэдэд олгосон барилгын салбарын чанаргүй зээл 25.4 хувьтай байна.

Зураг 16. ЖДҮ-ийн чанаргүй зээлийн хувь



ЖДҮ эрхлэгчдэд олгож буй зээлийн жигнэсэн дундаж хүү болон хугацааг харьцуулахад иргэдэд олгосон зээл 19.7 хувиас 27.2 хувийн хүүтэй, хугацааны хувьд 6.3 сараас 3.2 жилийн хооронд байгаа бол аж ахуйн нэгжид олгосон зээл 14.9 хувиас 21.2 хувийн хүүтэй, хугацааны хувьд 1.3 жилээс 2.3 жил хүртэл хугацаатай олгогдсон байна. Харин ЖДҮ эрхлэх зориулалтаар иргэдэд олгосон зээлийн хувьд барилгын салбар хамгийн өндөр хүүтэй буюу 27.2 хувийн хүүтэй 2.9 жилийн хугацаатай олгогджээ.

Зураг 17. ЖДҮ-ийн зээлийн хүү, хугацаа

